

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Ярилцлага өгөгчийн нэр	Мөнхтоогоо	Дугаар	L365
Оршин суугаа аймаг	Орхон	Оршин суугаа сум	Баян-Өндөр сум, Хүрэн булаг баг
Төрсөн газар	Баян-Өндөр сум	Төрсөн он	
Ажил мэргэжил	Тэргүүн хамба		
Лам байсан эсэх, Шавилан сууж байсан сүм хийд		Сүм хийдийн дугаар	
Одоогийн сүм хийд	Ганданшадивлан	Сүм хийдийн дугаар	ОРӨӨ 001
Ярилцлага авсан он сар өдөр	2007 оны 8-р сарын 6	Ярилцлага авсан хүн	Д.Мөнхбат

Орхон аймгийн Баян-Өндөр сумын Ганданшадивлан хийд

Энэ хийд 300 гаруй жилийн тэртээ одоогийн Булган аймгийн Хангал сум, тэр үеийн Түшээт хан аймгийн Дайчин вангийн хошууны хурал номын томоохон газрын нэг байсан Хутагт ламын хүрээний үргэлжлэл болж Баян-Өндөр сумын нутагт байгуулагдсан манай Хутагт Ламын хийд Ганданшадивлан нь 1990 оны 6 сарын дунд үеээс үйл ажиллагаа тасралтгүй явуулж ирсэн. Орхон аймгийн болон Булганы ойролцоох сумдынхаа сүсэгтэн олонд буян номыг ёс дэг жагсийн дагуу хуран гүйцэтгэж байгаа.

Манай хийд өдөр тутам чогчин уншлагатай , үүнээс гадна бурхан болооч нарын захиалгын хурал, өөрөөр хэлбэл Ганжүүр гэсэн хурал бараг өдөр тутам уншигдаж байдаг. Шинийн 8нд Их манал, 15нд Жүд, Сандуйн Жүд, 25 нд Гүнрэг юм уу Цэгмидийн чог, Диваазын чог ч юм уу янз бүрийн чогуудыг хурж байгаа. Шинийн 29нд сахиусаа тахидаг. Сар бүр 3 сахиус уншдаг. Хаврын эхэн сар дунд сар гэхэд 10 Хангалаа гурав гурваар нь хуваагаж, сахиусаа хурдаг. Битүүндээ бол Сожин уншаад, Найдан чоого хурдаг.

Манай хийдийн нийт 25 ламтай. Манаач, тогочон гээд 5 хүнтэй. Нийт 30 хүний бүрэлдэхүүнтэй үйл ажиллагаагаа явуулж байгаа юм. Шашны Дээд Сүргүүль төгссөн 3, дунд сүргүүль төгссөн 3 лам байдаг. Энэ жил Шашны Дээд Сүргүүль нэг лам, Энэтхэгийн Гомон дацанд 1 лам сурч байгаа. Энэ 9 сарын дундуур дахин 2 лам Гомон дацанруу явуулах гэж байгаа. Боловсон хүчний хувьд иймэрхүү байдалтай байна.

1990 оноос хойш манай хийдийн хамба нар олон удаа солигдсон учраас хөрөнгө завшигдсан байдал гарсан. Энэ бүгдийг засч залруулаад 1999 оноос үйл ажиллагаа нь жигдрээд явж байна.

2002 онд 14х14 гэсэн харьцаатай дуган байгуулаад хурал номоо хурж байгаа. Хийдийнхээ эргэн тойронд 2 сүврагатай, 2 том дүнчүүр маанийн хүрдтэй, дуганыхаа үүдэнд 21 жижиг хүрдтэй, туслах гал тогоо, 6

Энэхүү нэр дурдсан хүний аман ярилцлагын үнцлэсн тэмдэглэл нь зөвхөн ярилцлагчийн хувийн мэдээллээс бүрдсэн болно. © Монголын Урлагийн Зөвлөлийн Соёлын Өвийн Хөтөлбөр, Монголын Сүм хийдийн түүхэн товчоон

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

байх бөгөөд доороо гэр хэлбэртэй дугантай байна. . Бурхан багшийн 2 талаар нь бурхан багшийн 8 сүврага дөрөв дөрөөрөө байрлана. Гэрэлт хөшөө байна, мөргөлийн тавцан байна, гэрэлтүүлэг зам харгүй гэсэн иймэрхүү цогцолбор байдлаар нь шийдэхэд бол нийт зураг төсвийн өртөг бол одоогийн байдлаар 3 тэрбум төгрөг тусгаад байна. Энэний гол санхүүжүүлэгч бол Уулын Баяжуулах Үйлдвэр, советийн хуралаараа шийдээд ерөнхий хөрөнгө оруулалтын 50 хувийг хийе гээд хийгдээд явж байна, одоогийн байдлаар газар шорооны ажил хийгдээд явж байна, тогоо татсан байгаа. Бурхан багшийг хийх хэвний ажил ид хийгдээд байж байна. Хэвний ажил бол энэ 8 сардаа дуусаад, 9 сараас бол ерөнхийдөө бурхнаа цутгах ийм ажил маань эхлэнэ. Бурханаа бүтээсний дараа нэг гол асуудал бол сүншигийн асуудал байдаг, тэгээд амин модыг олох асуудал байдаг энийг бид Бүрэнхан гэдэг уулнаас амин модоо татахаар болоод Баруунбүрэн сумын засаг даргатай тохиролцоод ирэх 7 хоногоос амин модооо татна. Тэгээд энд бол арцны асуудал бас их хүндрэлтэй байдаг юм байна. Арц нь Монгол улсын хэмжээгээр олдоц муутай, ховор ургадаг ургамалын тоонд орж байна. Иймээс Завхан аймаг Архангай аймаг гэсэн 2 аймаг дээр товллоод газар дээр нь очиж цуглуулах ажил зохион байгуулах . Тэгээд ховор нандин Бурхан багшийн чандар, пэлдэн энэ тэр гээд ийм ховор нандин юмнуудыг нь Монгол Ринбүчи багшаас болон Бурхан шашны төв Гандан хийдэд хандаж олох ийм л ажлууд явагдаж байна.

Бурханы дэг жагсийн хувьд бол манай анхны хуралаас эхлээд л яригдсан асуудал. Гол нь Монголдоо бүтээгдэж байгаа, Бурхан багшийг бүтээх Балба хийц, урд Хятад зүгийн хийц, Жагар хийц гээд олон янзын хийц байдаг, энэ бүгдээс хэлцэж байгаад ер нь Өндөр гэгээний Монгол төрхийг хадгаласн ийм байдлаар бүтээе гэж тохироод Урчуудын хороо, Төрийн соёрхолт ардын зураач Амгалан гуай ерөнхий баримал хэв гаргах дээр түлхүү ажиллаж байгаа. Зүргийн тэг дээр бол Бурханч лам Пүрэвбат лам гуайд хандаад, хамгийн сүүлийн 1х1 гэсэн макет дээр Пүрэвбат ламыг залж авчиргаад, санал шүүмжлэлийг аваад, зэ энэ болжээ гэдгийг Пүрэвбат лам гуай хэлсэн, мөн холбогдох ламба гуай нар байсан, мөн комиссынхон байлцаж макетаа гаргасан. Одоо бол хэв бол тэр тэгийнхээ дагуу явагдаж байгаа. Бурхан бүтээж байх явцад бол, Өндөр гэгээний тэг гэж байдаггүй юм байна, Өндөр гэгээний хийц гэж байдаг юм байна. Бурхан багшийн тэг бол Бурхан багшийн үеэс нь гарсан байсан, ийм уламжлалтай юм байна лээ.

Манай хийд өдөр тутам чогчин уншлагатай , үүнээс гадна бурхан болооч нарын захиалгын хурал, өөрөөр хэлбэл Ганжүүр гэсэн хурал бараг өдөр тутам уншигдаж байдаг. Шинийн 8нд Их манал хурдаг, 15нд Жүд, Сандуйн Жүдээ хурцдаг, 25 нд Гүнрэг юм уу Цэгмидийн чог, Диваазын чог ч юм уу янз бүрийн чогуудыг хурж байгаа юм. Шинийн 29 сахиусаа тахидаг. Сар бүр 3 сахиус уншдаг. Хаврын эхэн сар дунд сар гэхэд 10 Хангалаа гурав гурваар нь хуваагаад ингээд сахиусаа ингэж хурдаг. Битүүндээ бол Сожин уншаад, Найдан чоого хурдаг. Санхүүгийн хувьд бол сүсэгтэн олныхоо уншуулж байгаа, айлтүүлж байгаа тэрнээс гол эх үүсвэр санхүүжиж байгаа. Дээр нь бол томоохон хурал номыг дааж унших ч юм уу томоохон бүтээн байгуулалт дээр, томоохон хэмжээний жандагуудад оролцдог л доо. Манайх бас шашны дэлгүүр ажиллуулдаг. Тэндээс зарим нэг дутагдалтай санхүүжилт дээрээ хэрэгжүүлдэг. Шинэлэг талаас гэх юм бол Гандан компьютер дээр ном бичиж байгаа тэрийг Гандан хард энэ тэрийг нь өгөөд компьютерт оруулах иймэрхүү ажил бас хийж байгаа. Сар

Энэхүү нэр дурдсан хүний аман ярилцлагын үнцлэсн тэмдэглэл нь зөвхөн ярилцлагчийн хувийн мэдээллээс бүрдсэн болно. © Монголын Урлагийн Зөвлөлийн Соёлын Өвийн Хөтөлбөр, Монголын Сүм хийдийн түүхэн товчоон

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

лам нарын орон сууц, нярав нягтлангийн ажлын өрөө гэсэн туслах барилгуудтай үйл ажиллагаагаа явуулж байна.

Санхүүгийн хувьд бол сүсэгтэн олныхоо ном уншуулж, айлтүүлж байгаа мөнгөөр л гол эх үүсвэр санхүүжиж байгаа. Дээр нь томоохон хурал номыг дааж унших ч юм уу, томоохон бүтээн байгуулалт дээр, томоохон хэмжээний жандагуудад оролцдог. Мөн манайх шашны дэлгүүр ажиллуулдаг. Тэндээс зарим нэг дутагдалтай санхүүжилтээ нөхөж чаддаг. Шинэлэг зүйл гэвэл компьютерт ном оруулах ажил бас хийж байгаа. Сар улирал тутам тайлан өгч байгаа. Манай Бурханы шашны төв нь төрийн өндөрлөгүүдэд хүсэлт тавьснаар хуулинд өөрчлөлт оруулж 2007 оны 1 сараас ашгийн татвар өгөхөөргүй болсон нь хийдийн хөгжилд нэмэр болж байна.

Энэ бол Ашгийн татвар өгдөг байхад чанга байсан. Сүм хийдээс 20 хувь гэж байсан. 1 сая төгрөгийн хандив орлоо гэхэд 200000 мянга нь татварт, өгөх хэцүү, байх хэцүү байсан. Одоо бол бас гайгүй. Гэхдээ бас бусад татварын юмнууд буураагүй шүү дээ. Хүн амын орлогын албан татвар, Эрүүл мэнд гэх мэт, татварууд байгаа.

Бид лам нарынхаа эздийг тогтмол маягаар шийдсэн. Сар бүр Монгол Улсын Хөдөлмөрийн хуулийнд заасан доод түвшин 70 мянган төгрөг, дээд хүн маань зүү гаргаад авч байх жишээтэй. Ер нь Хөдөлмөрийн хуулийн хэмжээнд л ажиллаж байгаа. Тэгэхгүй бол Хөдөлмөрийн үйлдвэрчний хорооноос заримдаа шалгалт орж ирээд гомдол санал гардаг. Эрүүл мэндийн даатгалыг лам нар төлж байгаа байх. Нийгмийн даатгалыг бол Төр Сүм хийдийн Харилцааны тухай хуулинд лам нар сайн дурын үндсэн дээр төлж болно гэсэн заалтыг үндэслэл болгоод 1997 онд хүсэлт тавиад болиулсан.

Эрдэнэт хотынхоо хойморт, Баян-Өндөр уулынхаа өвөрт нийт эрдэнэтчүүддээ зориулж, хотыг тойрсон аймгуудын бүс нутгийн сүсэгтэн олонд зориулсан Бурхан багшийн сэрэг дүрийг бүтээх ажил ид өрнөөд байна.

Энэ ажлыг 2 жилийн өмнө манай засаг дарга Хутагт ламын хийд дээр маань ирээд бидний ажилтай танилцаад явж байх үед манай хийдийн зүгээс тавьсан. Одоогийн байдлаар 17 метр биш 5 метртэй Бурхан багш байлгаа. Тэгээд гадуур нь сүм дуганатай байа гэсэн. Ингэж яриад засаг дарга дэмжээд энэ яриа өндөрлөсөн. 2006 онд засаг дарга биднийг дуудаад, энэ асуудал дээр санал солилцсон. Би гадаад орноор их явлаа ер нь харж байхад Солонгос, Тайланд, Япон зэрэг оронд Бурхан багшийгаа том хэмжээгээр бүтээсэн байдаг юм байна. Тэгэхлээр бид бас Орхон аймагтаа Бурхан багшийг томоохон хэмжээний цогцолбор маягаар бүтээе гэсэн санал тавьсан. Бид дэмжээд ажлын хэсэг байгуулах, ямар хэлбэрээр ажлаа явуулах талаар Иргэдийн хуралдаа өргөх бичиг бариад санал тавьсан. Иргэдийн хурал комиссыг маань батласан. Засаг дарга энэ комиссыг даргалж байгаа. Уулын Баяжуулах Үйлдвэрийн Наранхүү захирал орлогч даргаар, гишүүд нь миний бие мөн Орхон аймгийн пүүс компаний захиралууд гэх мэт 11 хүний бүрэлдэхүүнтэй өнгөрсөн жил байгуулагдаад, анхны хурлаа хийсэн. Хандив цуглуулан Бурхан багшийн сэрэг дүрийг барина гэдэг манай Монголын татварын нөхцөлд асуудалтай юм байна гэж ярилцаад Эрдэнэт цогцолбор сан гэж байгуулаад сангийн чиглэлээр үйл ажиллагаагаа явуулж байгаа. Бурхан багш маань нийт 17 метр, зэсээр цутгасан алтадмал

Энэхүү нэр дурдсан хүний аман ярилцлагын үнцлэсн тэмдэглэл нь зөвхөн ярилцлагчийн хувийн мэдээллээс бүрдсэн болно. © Монголын Урлагийн Зөвлөлийн Соёлын Өвийн Хөтөлбөр, Монголын Сүм хийдийн түүхэн товчоон

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

улирал тутам тайлан өгч байгаа. 2007 оны ашгийн татвар 1 сараас авахгүй болсон нь бас хийдийн хөгжилд нэмэр болж байна.

Манай Орхон аймгийн нутаг дэвсгэр дээр Бурхан багшийн сэрэг дүрийг босгох ажил эд өрнөөд байж байна. Энэ ажлыг 2 жилийн өмнө манай засаг дарга Хутагт ламын хийд дээр маань ирээд бидний ажилтай танилцаад явж байх үед энэ саналыг манай хийдийн зүгээс тавьсан. Анх бид ярьж байсан одоогийн байдлаар 17 метр биш 5 метртэй Бурхан багш байа гэж яриад тэгээд гадуур сүм дуганатай байа гэсэн. Ингэж яриад засаг дарга дэмжээд энэ яриа өндөрлөсөн. 2006 онд засаг дарга биднийг дуудаад, энэ асуудал дээр санал солилцсон. Би гадаад орноор их явлаа ер нь харж байхад Солонгос, Тайланд Япон зэрэг оронд Бурхан багшийгаа том хэмжээгээр бүтээсэн байдаг юм байна. Тэгэхлээр бид бас Орхон аймагтаа Бурхан багшийн томоохон хэмжээгээр цогцолбор маягаар бүтээе гэсэн санл тавьсан бид дэмжээд ажлын хэсэг байгуулах, ямар хэлбэрээр ажлаа явуулах талаар Иргэдийн хуралдаа өргөх бичиг бариад санал тавьсан. Иргэдийн хурал энэ комиссыг маань батласан. Засаг дарга энэ комиссыг даргалж байгаа. Уулын Баяжуулах Үйлдвэрийн Наранхүү захирал орлогч даргаар, гишүүд нь миний бие мөн Орхон аймгийн пүүс компаний захиралууд гэх мэт 11 хүний бүрэлдэхүүнтэй ноднин байгуулагдаад, анхны хурлаа хийгээд. Хандив цуглуулаад Бурханы сэрэг дүрийг барина гэдэг манай Монголын татварын нөхцөлд асуудалтай юм байна гэж ярилцаад Эрдэнэт цогцолбор сан гэж байгуулаад сангийн чиглэлээр үйл ажиллагаагаа явуулж байгаа. Бурхан багш маань нийт 17 метр, зэсээр цутгаад дараад алтадна. Доороо бол гэр хэлбэртэй дугана . Бурхан багшийн 2 талаар нь бурхан багшийн 8 сүврага дөрөв дөрөөрөө байрлана. Гэрэлт хөшөө байна, мөргөлийн тавцан байна, гэрэлтүүлэг зам харгүй гэсэн иймэрхүү цогцолбор байдлаар нь шийдэхэд бол нийт зураг төсвийн өртөг бол одоогийн байдлаар 3 тэрбум төгрөг тусгаад байна. Энэний гол санхүүжүүлэгч бол Уулын Баяжуулах Үйлдвэр, советийн хуралаараа шийдээд ерөнхий хөрөнгө оруулалтын 50 хувийг хийе гээд хийгдээд явж байна, одоогийн байдлаар газар шорооны ажил хийгдээд явж байна, тогоо татсан байгаа. Бурхан багшийг хийх хэвний ажил ид хийгдээд байж байна. Хэвний ажил бол энэ 8 сардаа дуусаад, 9 сараас бол ерөнхийдөө бурхнаа цутгах ийм ажил маань эхлэнэ. Бурханаа бүтээсний дараа нэг гол асуудал бол сүншигийн асуудал байдаг, тэгээд амин модыг олох асуудал байдаг энийг бид Бүрэнхан гэдэг уулнаас амин модоо татахаар болоод Баруунбүрэн сумын засаг даргатай тохиролцоод ирэх 7 хоногоос амин модооо татна. Тэгээд энд бол арцны асуудал бас их хүндрэлтэй байдаг юм байна. Арц нь Монгол улсын хэмжээгээр олдоц муутай, ховор ургадаг ургамалын тоонд орж байна. Иймээс Завхан аймаг Архангай аймаг гэсэн 2 аймаг дээр товллоод газар дээр нь очиж цуглуулах ажил зохион байгуулах . Тэгээд ховор нандин Бурхан багшийн чандар, пэлдэн энэ тэр гээд ийм ховор нандин юмнуудыг нь Монгол Ринбүчи багшаас болон Бурхан шашны төв Гандан хийдэд хандаж олох ийм л ажлууд явагдаж байна.

Бурханы дэг жагсийн хувьд бол манай анхны хуралаас эхлээд л яригдсан асуудал. Гол нь Монголдоо бүтээгдэж байгаа, Бурхан багшийг бүтээх Балба хийц, урд Хятад зүгийн хийц, Жагар хийц гээд олон янзын хийц байдаг, энэ бүгдээс хэлцэж байгаад ер нь Өндөр гэгээний Монгол төрхийг хадгалсан ийм байдлаар бүтээе гэж тохироод Урчуудын хороо, Төрийн соёрхолт ардын зураач Амгалан гуай ерөнхий баримал хэв гаргах дээр

Энэхүү нэр дурдсан хүний аман ярилцлагын үнцлэсн тэмдэглэл нь зөвхөн ярилцлагчийн хувийн мэдээллээс бүрдсэн болно. © Монголын Урлагийн Зөвлөлийн Соёлын Өвийн Хөтөлбөр, Монголын Сүм хийдийн түүхэн товчоон

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

түлхүү ажиллаж байгаа. Зургийн тиг дээр бол Бурханч лам Пүрэвбат лам гуайд хандаад, хамгийн сүүлийн 1х1 гэсэн макет дээр Пүрэвбат ламыг залж авчираад, санал шүүмжлэлийг аваад, за энэ болжээ гэдгийг Пүрэвбат лам гуай хэлсэн, мөн холбогдох ламба гуай нар байсан, мөн комиссынхон байлцаж макетаа гаргасан. Одоо бол хэв бол тэр тигийнхээ дагуу явагдаж байгаа. Бурхан бүтээж байх явцад бол, Өндөр гэгээний тиг гэж байдаггүй юм байна, Өндөр гэгээний хийц гэж байдаг юм байна. Бурхан багшийн тиг бол Бурхан багшийн үеээс нь гарсан байсан, ийм уламжлалтай юм байна лээ.